

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДОТООД АУДИТЫН
2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

2026 оны 06 дугаар сарын 26

Улаанбаатар хот

Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хууль зүй, дотоод хэргийн сайдын дэргэдэх Дотоод аудитын хорооны 2017 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын журам”, байгууллагын дотоод аудитын 2026 оны төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Санхүү, нийцлийн чиглэлээр

Дотоод аудитын төлөвлөгөөний дагуу санхүүгийн чиглэлээр 2, нийцлийн чиглэлээр 2, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2, нийт 6 удаагийн төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, үр дүнг байгууллагын удирдлагад илтгэх хуудсаар танилцуулан холбогдох арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

Хяналт шалгалтыг төрлөөр нь ангилбал: Хүснэгт 1

Д/д	Хяналт, шалгалтын төрөл	Хамрагдсан зохион байгуулалтын нэгжүүд	Хяналт шалгалтын тоо	Тайлбар
1	2	3	4	5
1.	Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр	2026 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа Санхүү, хангалт үйлчилгээний газарт	1	төлөвлөгөөт
		Баруун бүс дэх газарт	1	төлөвлөгөөт
2.	Нийцлийн чиглэлээр	2026 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа Санхүү, хангалт үйлчилгээний газарт	1	төлөвлөгөөт
		Баруун бүс дэх газар	1	төлөвлөгөөт
3.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд	Төв болон орон нутаг дахь нэгжүүд	2	төлөвлөгөөт

Дотоод аудитын хяналт шалгалтыг дэлгэрэнгүйгээр танилцуулбал:

- Байгууллагын даргын баталсан 04 дүгээр сарын 27-ны өдрийн 01-08/04 дүгээр удирдамжийн дагуу энэ онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд дотоод болон нийцлийн аудитын хяналт шалгалтыг хийж, үр дүнг 05 дугаар сарын 11-ний өдрийн 01-08/09 дүгээр илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулан, зөвлөмжийг 05 дугаар сарын 13-ны өдрийн 08/19 дүгээр албан бичгээр хүргүүлсэн.

- Байгууллагын даргын баталсан 05 дугаар сарын 25-ны өдрийн 01-08/05 дугаар удирдамжийн дагуу Баруун бүс дэх газрын санхүүгийн үйл ажиллагаа, хууль эрх зүйн хүрээнд батлан гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд 05 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 04-ний өдрүүдэд дотоод болон нийцлийн аудитын хяналт шалгалтыг зохион байгуулан, үр дүнг 06 дугаар сарын 05-ны өдрийн 01-08/11 дүгээр илтгэх хуудсаар байгууллагын удирдлагад танилцуулан, зөвлөмжийг 06 дугаар сарын 11-ний өдрийн 08/1110 дугаар албан бичгээр хүргүүлэв.

Хоёр. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн чиглэлээр

Тайлант хугацаанд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд төв болон харьяа 7 нэгжид 2 удаагийн удирдамжийн дагуу дотоод аудит хийж, үр дүнг байгууллагын удирдлагад 2 удаагийн илтгэх хуудсаар танилцуулж, зөвлөмж хүргүүлэн биелэлтийг хангуулан ажилласан.

Шилэн дансны тухай хуулийн 2025 оны IV, энэ оны I дүгээр улирлын хэрэгжилтийг хүснэгт 1 харуулбал:

Д/д	Байгууллагын нэр	Удирдамж, илтгэх хуудасны огноо, дугаар	Зөвлөмжийн огноо, дугаар	Зөвлөмж ирүүлсэн огноо, дугаар	Биелэлтийн хувь
1	2	3	5		6
1.	Хойд бүс дэх газар	Удирдамжийн огноо, дугаар: 2026.01.06 01-08/01, 2026.04.27 01-08/03	2026.04.23 08/748	2026.05.29 15/30	70%
2.	Баруун бүс дэх газар	Илтгэх хуудасны огноо, дугаар: 2026.01.14 01-08/03, 2026.04.17 01-08/08	2026.04.23 08/748	2026.04.24 14/42	100%
	Нийт	-			85%

Гурав. Дээд шатны байгууллагыг мэдээ, мэдээллээр хангаж ажилласан чиглэлээр

Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний аудитын газрыг дараах мэдээ, мэдээллээр хангаж ажиллалаа. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн 2025 оны 4 дүгээр улирал, 2026 оны 1 дүгээр улирлын тайланг 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/68, 04 дүгээр сарын 21-ний өдрийн 08/738 дугаар албан бичгээр;
- Байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээллийн хамт 04 дүгээр сарын 28-ны өдрийн 01/781 дүгээр албан бичгээр;
- Эрсдэлийг сааруулах үйл ажиллагаа буюу хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 82 хувьтай үнэлэгдэж, эрсдэлийн үнэлгээний хагас жилийн тайланг 08/1053 дугаар албан бичгээр 06 дугаар сарын 08-ны өдрийн 08/1053 дугаар албан бичгээр;
- Үндэсний аудитын газрын 2025 оны санхүүгийн аудитаар илэрсэн байгууллагад холбогдох зөрчлийг арилгах зөвлөмжийн хэрэгжилтийг 06 дугаар сарын 26-ны өдрийн 08/1224 дүгээр албан бичгээр хүргүүлэн ажилласан.

Дөрөв. Бусад асуудлаар

Байгууллагын эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн 2025 оны тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт 01 дүгээр сарын 28-ны өдрийн 01/193 дугаар албан бичгээр хүргүүлж, 03 дугаар сарын 17-ны өдрийн 01/326 дугаар албан бичгээр эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийн талаар дээрх байгууллагаас

зөвлөмж ирүүлсний дагуу 04 дүгээр сарын 01-ний өдөр байгууллагын эрсдэлийн удирдлагын төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтэд нь хяналт тавин ажиллаж байна.

Байгууллагын даргын 02 дугаар сарын 10-ны өдрийн 01-08/02 дугаар удирдамжийн дагуу байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн 01-08/04 дүгээр илтгэх хуудсаар удирдлагад танилцуулсан. Мөн албан хаагчдаас 03 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилттэй холбогдуулан судалгааг авч нэгтгэн 01-08/06 дугаар илтгэх хуудсаар үр дүнг удирдлагад танилцуулж, төрийн байгууллагуудын дотоод удирдлагын нэгдсэн систем (erp)-д 03 дугаар сарын 20-ны өдөр нийтэлсэн.

Байгууллагын хэмжээнд үйлчилж байгаа захиргааны болон захиргааны хэм хэмжээний нийт 24 актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн 05 дугаар сарын 18-ны өдрийн 08/22 дугаар дотоод албан бичгээр Захиргаа, удирдлагын газарт хүргүүлэв.

Байгууллагын хэмжээнд зохион байгуулсан 8 удаагийн сургалт, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулсан 3 удаагийн сургалт, зөвлөгөөнд албан хаагчид хамрагдсан. Хэлтсийн дарга Хууль зүйн үндэсний хүрээлэнд 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулагдсан “Монгол Улсад оршин суугаа гадаадын иргэдийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын чиглүүлэгчээр оролцов.

Тайлант хугацаад байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хуралдаанд дотоод аудит хариуцсан ахлах мэргэжилтэн 1 удаа, ёс зүйн дэд хорооны хуралдаанд нийцлийн аудит хариуцсан ахлах мэргэжилтэн 5 удаа хамрагдлаа.

-----oOo-----